



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 16 өдөр

Дугаар 9/339

Мандалговь

Зохион байгуулалтын арга хэмжээ  
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", "ж", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 35 дугаар хурлын шийдвэр, аймгийн Онцгой комиссын 2020 оны 20 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан, шинэ коронавирус (КОВИД-19)-ийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд соёл, урлаг, спорт болон олон нийтийг хамарсан бүх төрлийн үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цагаас 12 дугаар сарын 1-ний өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд түр хориглосугай.

Хоёр. Аймгийн хэмжээнд бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цагаас 12 дугаар сарын 1-ний өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд түр зогсоосугай.

Гурав. Архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй газруудын зөвхөн архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цагаас 12 дугаар сарын 1-ний өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд түр хориглосугай..

Дөрөв. Хот, аймаг, сум хоорондын зорчигч тээврийн хөдөлгөөнийг 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цагаас 12 дугаар сарын 1-ний өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд түр хориглосугай.

Тав. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ж.Мөнхчулуун), Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), болон холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, удирдлага, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



482010921